



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/59/

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд бүрийн язгуур эрх ашгийг ханган, өрх, гэр бүлийн аж байдлыг сайжруулж, хүүхдэд ээлтэй аймаг болох зорилгын хүрээнд 2024-2028 он хүртэл хөгжүүлэх “Гэр бүлийг дэмжих дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Батбилгүүн (Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Х.Тайванбаатар (Мөрөн сумын Засаг дарга)

А.Алтанцоож (Аймгийн Цагдаагийн газрын дарга)

Б.Баярсайхан (Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга)

Ш.Отгон-Эрдэнэ (Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Мөнх-Аюуш (Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Л.Батцэцэг (Аймгийн Соёл урлагийн газрын дарга)

Б.Базардамбуу (Аймгийн Статистикийн хэлтсийн дарга)

Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах хяналтын улсын ахлах байцаагч)

Т.Раднаабуд (Аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Мөнгөнзул (Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Г.Төмөрбаатар (Аймгийн Ахмадын хорооны дарга)

Ц.Оюун-Эрдэнэ (Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга)

С.Отгонжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Гэр бүл, хүүхэд, залуучууд, жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Ч.Лхагвасүрэн (Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн)

Захирамж-2023

6712011357



Нарийн бичгийн дарга:

Ч.Дашбаяр (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

2. Хүүхэд, гэр бүлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаанд үндэслэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Тогтвортой хөгжлийн зорилго, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, "Хөгжсөн Хөвсгөл 2016-2030" зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан 2024-2028 онд хэрэгжүүлэх "Гэр бүлийг дэмжих дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсруулж, 2023 оны 12 дугаар сард аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

